



ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР
2020.02

ЭХХГ-ын үндсэн чиг үүрэг

Эрчим хүч хэмнэлтийн газар нь Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн дагуу дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Эрчим хүч хэмнэлтийн хууль, Төрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, шаардлагатай эрх зүйн баримт бичгийг сайжруулах санал боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
- Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, бүртгэх, эрчим хүч хэмнэхтэй холбоотой хөтөлбөр, төлөвлөгөө, тайлан гүйцэтгэлийг гаргуулж авах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;
- Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, төгсөгчдөд эрх, гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулах;

ЭХХГ-ын үндсэн чиг үүрэг /үргэлжлэл/

- Эрчим хүчний аудит болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг /ESCo/ магадлан итгэмжлэх эсэх саналыг хорооны хурлаар хэлэлцүүлэх, зохих шийдвэрүүдийг гаргуулах;
- Эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглээний талаар мэдээллийн систем бий болгох, нийтэд сурталчлах, танин мэдүүлэх ажлыг зохион байгуулах;
- Эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай зарцуулахад чиглэсэн олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, гаднын зээл, тусламжаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх, төслийн бэлэн байдлыг хангах;
- Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
- Төрийн нэгдсэн бодлогын хүрээнд эрчим хүчийг хэмнэх замаар хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах ажлыг зохион байгуулах;

Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд:

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар, байгууллага хоорондын уялдааг хангах, хамтран ажиллах хүрээнд СЯ, БХБЯ, БОАЖЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ, БСШУСЯ, НЗДТГ болон Олон улсын байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, тэдгээр байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг тогтоож, оролцогч талуудын мэдээлэл солилцох уулзалтыг **2019 оны 03 сар, 12 сард** тус тус зохион байгуулсан. Энэ ажлын үр дүнд холбогдох яамд, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүд нэгдсэн ойлголттой болж, үндэсний хөтөлбөрт туссан үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, уялдаа хангагдах нөхцөл бүрдэж байна.

Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх нэгдсэн тайланг боловсруулж ЭХЯ, ЗГХЭГ-т хүргүүлж ажилласан ба Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд Хорооны Дотоод аудитын газар болон ЭХЯ-аас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үндэсний хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилтийг **93.2%**-ийн биелэлттэй гэж дүгнэсэн бөгөөд тайланг Эрчим хүчний сайдын 2019 оны 03 сарын 29-ний өдрийн а/1200 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж Засгийн газарт тайлагнасан.

Эрчим хүч хэмнэлтийн эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгох, сайжруулах ажлыг зохион байгуулах хүрээнд:

Тайлант хугацаанд дараах журмуудыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн “Тогтоолын хавсралт шинэчлэн батлах тухай” **181** дүгээр тогтоолоор батлуулав.

- ✓ Эрчим хүчний аудит хийх журам
- ✓ Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам
- ✓ Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журам

“Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний жилийн хэрэглээний босго хэмжээг тогтоох тухай” **182** дугаар тогтоолыг шинэчлэн батлуулав.

Журмын шинэчлэлийн хүрээнд Хорооны **419** дүгээр тогтоолоор Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн “Эрчим хүч хэмнэх үйл ажиллагааны тайланг үнэлэх аргачлал”-ыг батлуулав. Мөн “Эрчим хүчний аудитын тайланг үнэлэх маягт, аудитын мэдээний маягт”-ыг Хорооны даргын **137** дугаар тушаалаар батлуулав.

Аргачлал, маягтуудыг батлуулсанаар үүрэг хүлээсэн хэрэглэгч, аудитор, магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, гүйцэтгэлийг үнэлэх нөхцөл бүрдэж байгаа юм.

Эрчим хүч хэмнэлтийн эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгох, сайжруулах ажлыг зохион байгуулах хүрээнд: /үргэлжлэл/

Хүлэмжийн хийн ялгаралтыг сааруулах Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний зорилтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, **эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээнээс ялгарч буй хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах** зорилтыг холбогдох бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээтэй уялдуулан ахиулан тодорхойлсон нь хүлэмжийн хийг бууруулахад чиглэсэн сан, олон улсын байгууллага, бусад эх үүсвэрээс хөрөнгө оруулалт татах боломж нэмэгдэж, арга хэмжээнүүдийг бодитой хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн. Уг бодлогын баримт бичгийг 2019 оны **11 сард** Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж баталсан.

Засгийн газрын тусгай сангуудын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 87 дугаар тогтоолын хүрээнд Сангийн яамнаас боловсруулсан **Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд** эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан үйл ажиллагааг дэмжих зохицуулалтыг бий болгох зорилгоор холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн нь дэмжигдэж УИХ-аар батлагдсан.

Эрчим хүч хэмнэлтийн эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгох, сайжруулах ажлыг зохион байгуулах хүрээнд: /үргэлжлэл/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд санал өгч “Ногоон худалдан авалт” гэсэн шинэ нэр томъёог тусгуулсан нь дэмжигдэж батлагдсан.

ЭСКо төсөл, үйл ажиллагаанд ашиглах “Эрчим хүчний гүйцэтгэлийн гэрээ”-ний жишиг загварыг боловсруулсан ба гэрээний загварт ДДНХБ-ын дэмжлэгээр хууль зүйн дүгнэлт гаргуулж, сайжруулах, холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэх ажлуудыг хийж, эцсийн тайлан, дүгнэлт, загвар гэрээг Хорооны удирдлагуудад танилцуулан цаашид зөвлөмж хэлбэрээр ашиглах боломжийг бүрдүүлэв.

- Барилга байгууламжийг эрчим хүчний хэрэглээ, хэрэгцээгээр ангилан гэрчилгээ олгох журмын төсөл;
- Барилгын материалыг эрчим хүчний үзүүлэлтээр ангилан шошго олгох журмын төсөл.

Эрчим хүчний хэмнэлтийг дэмжсэн үндэсний норм, стандартыг бий болгох ажлын хүрээнд:

Эрчим хүчний үр ашгийг тодорхойлох багц стандартыг орчуулах, хянах, хэлэлцүүлэх, санал авах, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгийн дэргэдэх Эрдмийн зөвлөл, Эрчим хүчний яамны шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх зэрэг шат дараалсан ажлуудыг хэрэгжүүлж Стандартчилал хэмжил зүйн газрын дэргэдэх Эрчим хүчний техникийн хороо, менежментийн хороогоор тус тус хэлэлцүүлэн үндэсний стандарт болгон батлуулав. Үүнд:

- IEC 60034-2-1:2014 Эргэлдэгч цахилгаан машин 2-1-р хэсэг: Туршилтаас алдагдал болон А.Ү.К-ийг тодорхойлох стандарт аргууд;
- IEC 60034-30-1:2014 Эргэлдэгч цахилгаан машин 30-1-р хэсэг: Сүлжээнээс ажилладаг хувьсах гүйдлийн хөдөлгүүрийн А.Ү.К-ийн ангилал (IE код);
- IEC 60076-20: 2017 Хүчний трансформатор–Бүлэг 20: Эрчим хүчний үр ашиг;
- IEC 60076-8:1997 Хүчний трансформаторын гарын авлага;
- ISO 50001:2018 Эрчим хүчний менежментийн тогтолцоо;
- ISO 50002:2014 Эрчим хүчний аудит хийх аргачлал түүнд тавигдах шаардлагууд;
- ISO 50003:2014 Эрчим хүчний менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалт гүйцэтгэх байгууллагад тавих шаардлага;

Эрчим хүчний хэмнэлтийг дэмжсэн үндэсний норм, стандартыг бий болгох ажлын хүрээнд: /үргэлжлэл/

ISO 50004:2014 Эрчим хүчний менежментийн тогтолцооны хэрэгжүүлэлт, хадгалалт, сайжруулалтын арга зүйн заавар;

ISO 50006:2014 Эрчим хүчний суурь түвшин, эрчим хүчний гүйцэтгэлийн үзүүлэлтийг ашиглан эрчим хүчний гүйцэтгэлийг хэмжих нь —Зарчим, арга зүйн заавар;

ISO 50007:2017 Эрчим хүчний хэрэглэгчдэд үйлчлэх үйлчилгээг үнэлэх, сайжруулах арга зүйн заавар;

DIN EN 16247-3 Эрчим хүчний аудит-Үйлдвэрлэл;

DIN EN 16247-4 Эрчим хүчний аудит-Тээвэр;

Мөн дараах стандарт, нормыг батлуулахад бэлтгэж орчуулах, хянах, сайжруулах, хэлэлцүүлэх, холбогдох байгууллагуудаас санал авах зэрэг ажлуудыг хийв. Үүнд:

DIN EN 834 Өрөөний халаах хэрэгслийн хэрэглээг тодорхойлох халаалтын зардал хуваарилагч;

БНБД 23-02-19 Барилгын дулаан хамгаалалт норм;

Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хүрээнд:

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 3.1.8-д заасны дагуу 2019 онд 100 аж ахуйн нэгж байгууллагыг шинээр үүрэг хүлээсэн хэрэглэгчээр тодорхойлж, нийт **229** хэрэглэгчийг бүртгээд байна.

Үүрэг хүлээсэн хэрэглэгчтэй хамтран ажиллах аяныг санаачлан зохион байгуулах удирдамжийг 2019.01.21-ны өдөр Хорооны даргаар батлуулан, 3 сард Улаанбаатар хотод байршилтай нийт **55** хэрэглэгчдэд хүрч ажилласан байна. Мөн 4-р сард **38** хэрэглэгчтэй уулзалт зохион байгуулж, ажлын тайланг Хорооны 2019.05.14-ны хуралд танилцуулсан. Аяны хүрээнд Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн эрчим хүч хэмнэх үйл ажиллагааг эрчимжүүлж, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, удирдлагын түвшинд нэгдсэн ойлголттой болох, нийт ажилтан албан хаагчид сургалт, мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөмж чиглэлээр хангагдсан үр дүнтэй арга хэмжээ болов.



Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах ажлын хүрээнд: /үргэлжлэл/

Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн 2018 оны тайлан, 2019 оны төлөвлөгөөг нэгтгэж, Хорооны удирдлагуудад танилцуулан, хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад Зөрчлийн тухай хуулийн дагуу мэдэгдэл хүргүүлэх, чиглэл өгөх зэрэг арга хэмжээ авч ажиллав.

Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн нэгдсэн зөвлөгөөнийг 11 сарын 14-нд зохион байгуулсан бөгөөд 152 орчим байгууллагын 200 төлөөлөгч оролцож мэдээлэл авч харилцан туршлага солилцов. Тус зөвлөгөөний үеэр аудитын байгууллагууд, эрчим хүчний үр ашигтай тоног төхөөрөмж борлуулдаг, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын үзэсгэлэнг зохион байгуулав.



Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийг бэлтгэх, мэргэшүүлэх, магадлан итгэмжлэл олгох ажлын хүрээнд:

Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийг бэлтгэх, мэргэшүүлэх сургалтыг гэрээт сургалтын байгууллагаар гүйцэтгүүлж, нийт 3 удаагийн сургалтаар 77 эрчим хүч хэмнэлтийн менежерийг бэлтгэв. Ингэснээр нийт 82 аудитор, 254 эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэгдэж, олгогдсон эрх, үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа гүйцэтгэж байна.



Тайлант хугацаанд эрчим хүч хэмнэлтийн менежерүүдийн туршлага солилцох уулзалт, аудиторуудын нэгдсэн зөвлөгөөнийг уламжлал болгон зохион байгуулж цаг үеийн мэдээ, мэдээллээр хангаж ажиллав.

Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийг бэлтгэх, мэргэшүүлэх, магадлан итгэмжлэл олгох ажлын хүрээнд: /үргэлжлэл/

№	ЭХ-ний магадлан итгэмжлэл бүхий байгууллагын нэр	Магадлан итгэмжлэл авсан							АМИ-ийн дуусах хугацаа	Хаяг	Аудитор		
		Үйл ажиллагааны төрөл	Регистрийн дугаар	Анх авсан огноо	Дугаар	Сулганы өг, сар, өдөр	Хүчинтэй хугацаа /жилийн	Сулганы тогтоолын огноо, дугаар			Овог нэр	Дугаар	
1	Мон-Энержи консалт Хязгаарлагдмал хариуцлагатай компани	Үйлдвэрлэл, үйлчилгээний болон барилгын эрчим хүчний аудит	2790017	2017.05.31	АМИ-001/2017	2019.05.31	3 жил	2019.06.05 281	2022.05.31	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дугаар хороо, Нэрны зам-82, Юнион Бюлдинг, А.-1005	Лодон Эрдэнэдалай Дашдулам Пүрэвдаваа Жаргалсайхан Энхтулга Нийдан Нямхай	ЭХА-У 041/2018 /д/ ЭХА-Б 010/2019 ЭХА-Б 011/2019 ЭХА-У 001/2019 /д/	
2	Шинэ эрчим инженеринг Хязгаарлагдмал хариуцлагатай компани	Үйлдвэрлэл, үйлчилгээний эрчим хүчний аудит	5880768	2017.05.31	АМИ-002/2017	2019.05.31	3 жил	2019.06.13 295	2022.05.31	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Ренталон ХХК-ийн байр, 212а тоот	Пунцаг Цэрэннадмид Шарав Баасанжав	ЭХА-У 014/2019 /д/ ЭХА-У 020/2019 /д/	
3	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн Төрийн өмчийн ААТҮГ	Үйлдвэрлэл, үйлчилгээний болон барилгын эрчим хүчний аудит	2541203	2017.05.31	АМИ-003/2017	2019.05.31	3 жил	2019.06.13 297	2022.05.31	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 19-р хороо, Х Чингүнжавын гудамж	Рагчаасүрэн Батмөнх Мөнхбаатар Амардалай Батцэцэг Төмөрчидэр	ЭХА-У 024/2017 /д/ ЭХА-Б 014/2017 ЭХА-У 030/2018 /д/	
4	БСД эрчим хэмнэлт Хязгаарлагдмал хариуцлагатай компани	Үйлдвэрлэл, үйлчилгээний эрчим хүчний аудит	6182858	2017.06.14	АМИ-004/2017	2019.06.14	3 жил	2019.06.13 298	2022.06.14	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Махатма гандийн гудамж, Релид харш 24-36 тоот	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19-р хороо, Чингисийн өргөн чөлөө, "Анум" төв	Цагаан Санлин Фейдорж Дашпунцаг Жаргал Доржпүрэв Онон Буян Баатар Болормаа Чулунтөмөр Батжаргал	ЭХА-У 005/2019 /д/ ЭХА-У 018/2019 /д/ ЭХА-У 003/2019 /д/ ЭХА-У 018/2019 /д/ ЭХА-У 025/2019 /д/ ЭХА-У 009/2019 /д/
5	Эрчим сүтээх хязгаарлагдмал хариуцлагатай компани	Үйлдвэрлэл, үйлчилгээний эрчим хүчний аудит	2826038	2017.06.14	АМИ-005/2017	2019.06.14	6 сар	2019.06.28 313	2019.12.14	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө, "Анум" төв	Гомбоосүрэнгийн Лувсан Мэхбармадын Чинбат	ЭХА-У 002/2017 /д/ ЭХА-У 017/2017 /д/	
6	Стэйт консалтинг Хязгаарлагдмал хариуцлагатай компани	Үйлдвэрлэл, үйлчилгээний болон барилгын эрчим хүчний аудит	5719208	2017.07.17	АМИ-006/2017	2019.07.17	3 жил	2019.07.04 364	2022.07.17	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, Барилга архитектур корпорацийн байр 318 тоот	Цагаалагийн Эрдэнэцогт Дамдинсүрэн Гантулга	ЭХА-У 007/2017 /д/ ЭХА-У 006/2017 /д/	
7	Киловатт цаг Хязгаарлагдмал хариуцлагатай компани	Эрчим хүчний аудит	6150055	2018.05.17	АМИ-007/2018		2 жил	243	2020.05.17	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 17-р хороо, 4-р хороолол, Амарсанаагийн гудамж, 73, 74 тоот	Ядмаа Содбаяр Дашзэвэг Цэгоо Мөнхөө Оюунбат Цэцэгдэл Нэцагдорж Дарь Содномдорж Сэрээтэр Батмөнх Дананшадэв Баасансүрэн	ЭХА-У 010/2017 /д/ ЭХА-У 035/2018 /д/ ЭХА-У 029/2018 /д/ ЭХА-У 040/2018 /д/ ЭХА-У 028/2018 /д/ ЭХА-У 039/2018 /д/ ЭХА-Б 009/2017	
8	Цэвэр Хязгаарлагдмал хариуцлагатай компани	Эрчим хүчний аудит	5838631	2018.05.17	АМИ-008/2018		2 жил	244	2020.05.17	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 12-р хороо, 6-р бичиг хороолол, Хаасбаатарын гудамж, 21, 82 тоот	Жав Оюунцэцэг Пүрэв Түмэн-Өлзий Батцэцэг Төмөрчидэр	ЭХА-У 042/2018 /д/ ЭХА-У 043/2018 /д/ ЭХА-У 030/2018 /д/	
9	Хүчит хөтлөг Хязгаарлагдмал хариуцлагатай компани	Эрчим хүчний аудит	6188001	2018.06.21	АМИ-009/2018		2 жил	254	2020.06.21	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Ривер студи хотжон 26а байр 107 тоот	Ондуй Батхурал Ишхэмц Агтансүвд Ломбо Гандансүрэн Чүлтэм Энхтулга	ЭХА-У 011/2017 /д/ ЭХА-Б 005/2017 ЭХА-У 019/2017 /д/ ЭХА-У 028/2017 /д/	
10	Түмэн амгалан ордон ХХК	Барилгын эрчим хүчний аудит	6321194	2019.11.07	АМИ-010/2019		2 жил	451	2021.11.07	УБ, БГД, 2-р хороо 2-р хороолол 40, 18	НХангайсайхан Л.Батсайхан Д.Гантулга Ц.Оюунцэцэг	ЭХА-Б 18/2018 ЭХА-Б 32/2018 ЭХА-Б 30/2018 ЭХА-Б 25/2018	
11	Би И И Си ХХК	Барилгын эрчим хүчний аудит	6391889	2019.11.07	АМИ-011/2019		2 жил	452	2021.11.07	Хан-Уул дүүрэг 10-р хороо, 64, 39 тоот	Жанжиндорж Гануул Буян Мөнхбаяр Даваням Дарамбаяр	ЭХА-Б 017/2019 ЭХА-Б 007/2019 ЭХА-Б 015/2019	
12	Эрчим хэмнэлт консалтинг ХХК	Үйлдвэрлэл, үйлчилгээний болон барилгын	6443028	2019.11.07	АМИ-012/2019		2 жил	453	2021.11.07	Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Энглос 3-1 байр, 2 тоот	Бадмаасүрэн Тогомаа Ишхэмц Агтансүвд Чүлтэм Энхтулга	ЭХА-У 028/2019 ЭХА-Б 005/2019 ЭХА-У 028/2019	

Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журмын дагуу хүсэлт ирүүлсэн 3 байгууллагад Эрчим хүчний аудитын магадлан итгэмжлэл олгосноор Эрчим хүчний аудитын 12 байгууллага, Эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх 1 байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Эрчим хүч хэмнэлтийн хууль, ач холбогдлыг сурталчлах, олон нийтэд таниулах ажлын хүрээнд:

Нийслэлийн боловсролын газартай хамтран Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг Төрийн болон Хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулиудын 1-5 дугаар ангиудад “Эрчим хүчний хэмнэлт-зохистой хэрэглээ” хичээлийг оруулах, сургалтын хөтөлбөрийг сайжруулах, сургагч багш нарыг бэлтгэх ажлыг зохион байгуулав. Энэхүү хичээлийг нийслэлийн хэмжээний **241** ерөнхий боловсролын сургуулийн **139000** гаруй сурагчдад сургалтын хөтөлбөрөөр дамжуулан заах нөхцлийг бүрдүүлсэн.

Орон нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Дархан-Уул, Дорнод аймгуудад Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ хичээлийг түгээн дэлгэрүүлэх сургалт зохион байгуулж, нийт **70** сургагч багшийг бэлтгэж, аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургуулиудын 1-5 дугаар ангийн сурагчдад хичээлийг зааж эхэлсэн. Уг хичээлийг заах үйл ажиллагаа тогтмолжих нөхцлийг бүрдүүлэх хүрээнд БСШУСЯ-ны газрын даргаар ахлуулсан бүх шатны сургалтын хөтөлбөрт “Амьдрах ухаан” хичээлийн цагт багтаан уг хичээлийг оруулах санал, хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг хамтран байгуулахаар тохиролцон ажиллаж байна.



Эрчим хүч хэмнэлтийн хууль, ач холбогдлыг сурталчлах, олон нийтэд таниулах ажлын хүрээнд: /үргэлжлэл/

Эрчим хүчний хэмнэлт, түүний ач холбогдлыг олон нийт, нийгэмд телевиз, радио, цахим орчин, сонин сэтгүүлээр дамжуулан сурталчлах ажлыг тухай бүрд хэрэгжүүлэн ажиллаж, эрчим хүчний хэмнэлтийн **23** төрлийн видео шторк, **10** төрлийн 15000 ш брошур, **5** төрлийн 5000 ш зурагт хуудсыг Үүрэг хүлээсэн хэрэглэгч, 21 аймгийн зохицуулах зөвлөлийн гишүүд, ерөнхий боловсролын сургуулиуд болон эрчим хүч түгээх, хангах байгууллагуудад хүргүүлж хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллав.



Эрчим хүчний хэмнэлтийн цахим мэдээллийн системийг үүсгэж үндэсний мэдээллийн сантай болох ажлын хүрээнд:

www.ecc.erc.gov.mn эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн цахим мэдээллийн системээр дамжуулан хэрэглэгч, олон нийтэд эрчим хүчний хэмнэлт, үр ашигтай хэрэглээний талаарх мэдээллийг тасралтгүй түгээх, Үүрэг хүлээсэн хэрэглэгч, төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагуудын эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээллийг тогтмол авч хэвших, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг онлайнаар хүлээн авч дүгнэх нөхцөлийг бүрдүүлээд байна.

Админ хуудас

Search...

Мэдээлэл

- 196 Текст мэдээлэл
- 53 Видео мэдээлэл
- 0 Санал асуулга
- 88082 Өзөхийн ханцалт

Админ хуудас

- Системийн хярагчид
- Хэрэглэгчийн төрөл
- Системийн тохиргоо
- УХХ рүү мэйл явуулах
- ЭХХ, Үр ашгийн тайлан
- Тайлан
- Төлөвлөгөө
- Магадлан итгэмжлэл хүсэгч
- Үүрэг хүлээсэн хярагчид
- Аудитор
- Аудитын байгууллага
- Эсхө байгууллага

Төлөвлөгөө/ 104

- Хэрэглэгчийн төрлөөр хайх -
Хайлт хийх...

Татаж авах

#	Байгууллага	Менежер	Он	Төлөв	Төлөвлөгөө оруулсан	Утас	Сүүлд шинэчилсэн огноо
1	ХААИС-ийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн Агроэкологи, бизнесийн сургууль	Б.Батбилэг	2020	Илгээсэн; Бөглөсөн;	Б. Батбилэг	99226233	2020-02-05 12:26:50
2			2020		Б. Батбаяр	91919806	2020-02-04 17:48:31
3	Монцемент билинг материалс ХХК	Я.Оргил-эрдэнэ	2020	Илгээсэн; Бөглөсөн;	Я. Оргил-Эрдэнэ	99033652	2020-02-04 16:27:03
4			2020		Ц.Батболд	91004046	2020-02-04 11:04:42
5	"Эрдэнэт ус,ДТС ОНӨХК	Г.Алтанчимэг	2020	Илгээсэн; Бөглөсөн;	Г.Алтанчимэг	91912159	2020-02-04 10:07:29
6	БТЕГ ХХК	Ц.Чулуунбаатар	2020	Баталгаажуулсан;	Б.Батсайхан	99409623	2020-01-31

Тайлан/ 99

- Хэрэглэгчийн төрлөөр хайх -
Хайлт хийх...

Татаж авах

#	Байгууллага	Менежер	Он	Төлөв	Тайлан оруулсан	Утас	Сүүлд шинэчилсэн огноо
1			2019		Н.Алтангэрэл	99992251	2020-02-05 14:53:10
2	Монцемент билинг материалс ХХК	Я.Оргил-эрдэнэ	2019	Баталгаажуулсан; Илгээсэн; Бөглөсөн;	Я. Оргил-Эрдэнэ	99033652	2020-02-04 16:04:28
3	УСУГ-ОНӨААТ-УУГ	Ж.Батжаргал	2019	Баталгаажуулсан; Илгээсэн; Бөглөсөн;	Ж.Батжаргал	91000903, 99273667	2020-02-03 15:52:32
4	Моннис пропертиес	Ч.Баатарцогт	2019	Баталгаажуулсан; Илгээсэн; Бөглөсөн;	Ч.Баатарцогт	99600750	2020-02-03 14:41:13
5	Улаанбаатар их дэлгүүр ХХК	Х.Зүчи	2019	Баталгаажуулсан; Илгээсэн; Бөглөсөн;	Х.Зүчи	89055050	2020-01-31 18:37:42
6	Гэмтэл Согор Судлалын Үндэсний Төв	О. Осор	2019	Баталгаажуулсан; Илгээсэн; Бөглөсөн;	О.Осор	91102111	2020-01-31 15:18:39

Орон нутагт эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Орон нутагт эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, аймгуудын “Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс”-ийн мэргэжилтнүүдэд Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр, байгаль орчин уур амьсгалын нөлөөлөл, орон нутгийн дулаан хангамжийн талаар чадваржуулах сургалтыг зохион байгуулж, мэдээллээр хангав.


Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 21 аймгийн 12 нь Эрчим хүч хэмнэх дэд хөтөлбөрийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаараа батлуулан хэрэгжүүлж эхэлсэн ба 9 аймаг Дэд хөтөлбөрөө боловсруулаад байна.



Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг сайжруулах төсөл хөтөлбөр, хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд:

Эрчим хүчний хэмнэлтийн хөрөнгө оруулалт, санхүүжилттэй холбоотой гаднын эх үүсвэрийг татах, эрчим хүчний үр ашгийн мэргэжлийн үйлчилгээ /ESCO/-г хөгжүүлэх, зах зээлийн механизмыг бүрдүүлэх, БНХАУ-ын эрчим хүчний хэмнэлтийн туршлагаас судлах, хоёр орны хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор тус улсын Үндэсний эрчим хүчний хэмнэлтийн төв, Хятадын үндэсний стандартчиллын хүрээлэнтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулан, санамж бичгийн хүрээнд ажиллах нарийвчилсан төлөвлөгөөгөө харилцан тохиролцов.

Барилга байгууламжийг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх, барилга байгууламжийн эрчим хүчний гэрчилгээ олгох, дулааны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр Барилга хот байгуулалтын яамтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав. Санамж бичгийн хүрээнд барилга байгууламжийг эрчим хүчний үзүүлэлтээр үнэлэн, гэрчилгээ олгох, барилгын материалыг шошгожуулах журмын төсөл боловсруулах ажлын хэсгийг Барилга хот байгуулалтын сайдын тушаалаар байгуулан, журмын төслийг боловсруулаад байна.



Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг сайжруулах төсөл хөтөлбөр, хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд: /үргэлжлэл/

Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг тоолох, мэдээлэх, үнэлэх талаар **NAMA** төсөлтэй хамтран ажиллаж, хүлэмжийн хийн тооллогын холбогдох журам, аргачлалыг боловсруулан, төслийг дуусгавар болгов. Мөн иргэдэд амины сууцны дулаан алдагдал, эрчим хүч хэмнэх боломжийн талаар мэдээлэл, зөвлөмж өгөх, угсармал орон сууцны дулаан алдагдлыг бууруулах, дулаалах ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр **NAMA FACILITY** санхүүжилтийн төсөл, хөтөлбөрийн санал боловсруулж холбогдох байгууллагуудыг дэмжиж ажиллав.

Монгол улсын Хөгжлийн банктай хамтран ажиллах талаар санал солилцох уулзалтыг 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан ба Эрчим хүчний зохицуулах хорооны удирдлагууд, ЭХЯ-ны төлөөлөл, Монгол улсын хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Б.Батбаяр, болон тус банкны удирдлагын багийн оролцсон тус уулзалтаар Эрчим хүчний салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилт, Эрчим хүчний хэмнэлтийн талаарх хууль эрх зүйн орчны талаар мэдээлэл өгч, хэмнэлтийн төслийг хүү багатай, урт хугацаат зээлээр санхүүжүүлэх боломжийг хэрхэн бүрдүүлж, хэрэгжүүлэх талаар санал солилцсон. Эрчим хүчний яам, Хөгжлийн банк, Эрчим хүчний зохицуулах хороо хамтран ажиллах санамж бичиг байгуулах саналыг дэвшүүлэн ажиллаж байна.



Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг сайжруулах төсөл хөтөлбөр, хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд: /үргэлжлэл/

Ногоон зээл, хөрөнгө оруулалт оруулах төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлоход ашиглах "Ногоон таксономи" буюу хүлэмжийн хий, агаар орчны бохирдлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, шалгуур үзүүлэлтийг боловсруулахаар Монголын банкны холбоо, ТоС Холбоо, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монгол банктай хамтран ажиллаж батлуулсан бөгөөд Сэргээгдэх эрчим хүч, Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр зээлийн бүтээгдэхүүнийг тодорхойлж, ангилал, шалгуур тогтооход санал тусгуулан ажиллав.

Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагатай 2017 онд байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийг эрчимжүүлэх, сэргээгдэх эрчим хүчний шингээлтийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, Олон улсын байгууллагын техникийн туслалцаа, хамтын ажиллагааны боломжийг нэмэгдүүлэх, хэмнэлтийн ЭСКО төслийг хэрэгжүүлэх гарцыг нээх, НАМА буюу хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээний 6 дах сонгон шалгаруулалтад хамтарсан төсөл бэлтгэж хүргүүлэх зэргээр хамтран ажиллаж байна.

Дүгнэлт

- ✓ Эрчим хүч хэмнэлтийн газар нь 2019 онд **Хорооны зорилтод** тусгагдсан 7, Ажлын албаар батлуулсан 30 томоохон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилт тавин **96** хувийн гүйцэтгэлтэй ажиллав.
- ✓ **Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр**, түүнийг хэрэгжүүлэх 18 зорилт, 85 арга хэмжээний 2019 онд хэрэгжүүлэхээр тусгасан 69 арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж **93** хувийн гүйцэтгэлтэй ажиллав.
- ✓ Тайлант онд Хорооны хурлаар **17** асуудал хэлэлцүүлж холбогдох шийдвэрүүдийг гаргуулав.
- ✓ Газарт ирсэн **290** албан бичгийг тухай бүр шийдвэрлэсэн ба **1195** албан бичгийг явуулж ажилласан байна.
- ✓ Хорооны даргын тушаалаар байгуулагдсан **5** ажлын хэсэг, Эрчим хүчний сайдын тушаалаар байгуулагдсан **2** ажлын хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар байгуулагдсан **2** ажлын хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар байгуулагдсан **3** ажлын хэсэг, Нийслэлийн засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт тус тус орж ажиллав.


ЭХХГ-ын 2020 оны зорилт

Монгол Улсын Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, дэвшилтэт техник, технологид суурилсан эрчим хүчний хангамж, хэрэглээний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг санаачлах, хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1. Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2020 онд хэрэгжүүлэхээр тусгасан 49 ажил, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх;
2. Эрчим хүчийг хэмнэх Монгол Улсын бодлогын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, эрх зүйн баримт бичгүүдийг сайжруулах санал боловсруулах;
3. Эрчим хүчний аудитор, Эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, сургагч багш нарыг шинээр болон давтан мэргэшүүлэх;
4. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх үйл ажиллагааг нь дэмжих, ЭСКо төслүүд болон бусад санхүүгийн хөнгөлөлттэй эх үүсвэрүүдээр үр ашгаа сайжруулахад хамтран ажиллах;
5. Эрчим хүчний менежментийн тогтолцоо MNS ISO 50001 стандартыг нэвтрүүлэх дотоодын хүний нөөц болон байгууллагыг чадавхжуулах, стандартыг цаашид хэрэглэгч бүр нэвтрүүлэх бүтэц бий болгох;
6. Нийтийн боловсролоор дамжуулан эрчим хүчний зохистой хэрэглээг сурталчлах тогтолцоог бүрдүүлэх, орон нутаг багш нарыг дадлагажуулах, хичээлийг заах ажлыг эхлүүлэх;
7. Шошгожуулах үйл ажиллагааг сурталчлах, бизнес эрхлэгчидтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, улс даяар шошгожуулах аян өрнүүлэх;

ЭРЧИМ ХҮЧЭЭ ХЭМНЭЖ ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАЙРЛАЦГААЯ!

<http://ecc.erc.gov.mn>



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗӨВ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИН ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХАД ТАНЫ ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР ЮМ



Та манай эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн цахим хуудсанд зочлоорой.